



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/188

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 3/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын даргын 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд “Covid-19”-ын цар тахалын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед аймагт тархсан халдварын нөхцөл байдал, цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи мэдээ, мэдээллийг иргэдэд шуурхай хүргэн ажиллах хавсралтад заасан хэвлэл мэдээллийн ажлын хэсгийн сэтгүүлч нарт олгох нэг удаагийн урамшуулалд 3000.0 төгрөг /гурван сая/-ийг баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 3000.0 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2021 онд 4.27-д батлагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah/A/188-Bg

Аймгийн Засаг даргын 2021 оны
04 дүгээр сарын 07-ны өдрийн
А/188 дугаар захирамжийн хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ГАМШГААС ХАМГААЛАХ ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН
БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ҮЕИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖЛЫН
ХЭСГИЙН СЭТГҮҮЛЧ НАРТ ОЛГОХ НЭГ УДААГИЙН УРАМШУУЛАЛ

ДД	Байгууллагын нэр	Сэтгүүлчийн нэр	Урамшуулалын дүн /төгрөгөөр/
1	Аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажилтан, ажлын хэсгийн ахлагч	Х.Алтантуяа	300000.00
2	Аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажилтан, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга	Х.Есэнкельд	300000.00
3	www.khovd.mn	Н.Таванцэцэг	300000.00
4	www.khovd.mn	О.Сайхандалай	300000.00
5	Олон ястан телевиз	Ц.Нямхүү	300000.00
6	Олон ястан телевиз	А.Энхгэрэл	300000.00
7	Ховд телевиз	Б.Самбалхүндэв	300000.00
8	Ховд телевиз	С.Жавзандулам	300000.00
9	Ховд телевиз	Б.Алтжин	300000.00
10	www.khovdnews.mn	Н.Батчимэг	300000.00
	Дүн		3000000.00

-oOo-